

		<p>Төрийн албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна /Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Эрүүгийн хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Хилийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн сонсголын тухай хууль г.м/</p>	<p>Эрх зүйн сургалт, сурталчилгааны 2017 оны төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 35 ажил арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 940 гаруй төрийн албан хаагчдад Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль тогтоомжуудаар тус тус сургалт зохион байгуулсан.</p>
		<p>Төрийн болон байгууллагын нууцын талаарх хууль тогтоомжийн сургалтыг үе шаттай зохион байгуулна</p>	<p>Төрийн болон байгууллагын нууцын тухай хууль 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан сургалт мэдээллийн ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна.</p>
		<p>Иргэд олон нийтийн хүний эрхийн талаарх боловсролыг нэмэгдүүлэн тэдний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны үр дүнг сайжруулна /АЭЗН-ийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 1.4.2/</p>	<p>Иргэд, олон нийтийн хүний эрхийн талаарх боловсролыг нэмэгдүүлэн тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр ХЭҮК-ийн Дорнод аймаг дахь ахлах мэргэжилтэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 15 ажил арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний дагуу Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 53 оюутан, ШШГА-ны 25 албан хаагч, Мэргэжлийн хяналтын газрын 25, Онцгой байдлын газрын 61 албан хаагчид болон Хэрлэн сумын 07 дугаар багийн 41 иргэнд хүний эрхийн ойлголт, хандлага сэдвүүдээр сургалт мэдээллийн ажил зохион байгуулсан. Хүний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлын хүрээнд ХЭҮК-ийн Дорнод аймаг дахь ахлах мэргэжилтэнд хүний эрхийн зөрчилтэй холбоотой 2 гомдол ирснийг гомдол хянан шалгах ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна.</p>
		<p>Хууль хяналтын байгууллагуудын хамтран хууль тогтоомжийн сургалтыг</p>	<p>Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль,</p>

		<p>нэгдсэн төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар зохион байгуулан ажиллана.</p>	<p>Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиудын сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулсан. Тус 5 өдрийн сургалтад аймгийн хууль хяналтын байгууллагын 120 албан хаагч хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2017 оны А/196 дугаар захирамжаар “Хил орчмын бүс нутагт нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үеийн хамтын ажиллагаа” сэдэвт хамтарсан команд штабын сургуулилтыг хууль хяналтын байгууллагууд хамтран 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтыг зохион байгуулснаар хууль хяналтын байгууллагууд онцгой нөхцөл байдал үүссэн үед харилцан ажиллах хамтын ажиллагаагаа тодотгосон.</p>
		<p>Хил орчмын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд болон хилчдэд Хилийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалт зөвлөгөөн зохион байгуулна /АЭЗН-ийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 1.4.7/</p>	<p>Аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ээлжит зөвлөгөөнийг 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Хилийн 0132 дугаар ангид зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд хилийн сумдын Засаг дарга нар болон шинээр элссэн 32 хил хамгаалалтад туслах хүчний гишүүн буюу малчид оролцож, хил хамгаалалтад туслах хүчний ээлжит зөвлөгөөнөөс 3 чиглэлийн хүрээнд 28 заалт бүхий зөвлөмжийг гаргасан.</p> <p>Хил орчмын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд болон хилчдэд Хилийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгох сургалтыг 2017 оны 06 дугаар сарын 25-наас 8 дугаар сарын 20-ныг хүртэл хугацаанд 9 застав 1 боомтын хариуцсан хэсэгт зохион байгуулсан. Тус сургалтад хил хамгаалах байгууллагын 172 албан хаагч 84 иргэнд хамрагдсан.</p>
		<p>Хэсгийн төлөөлөгчдэд хууль тогтоомжийн мэдлэг олгох нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулна.</p>	<p>Аймгийн Цагдаагийн газрын Хэсгийн төлөөлөгчдийн 2017 оны 09 дүгээр сарын цугларалтаар зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>
		<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албатай хамтран Засаг захиргааны анхан шатны нэгж багийн иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдэд “Орон нутгийн хөгжил-</p>	

		багаас” нэгдсэн сургалтыг зохион байгуулна.	
1.2	Төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд хууль тогтоомжийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хууль тогтоомжийн сургалт зохион байгуулна	Одоогоор сургалт зохион байгуулагдаагүй байна.
		Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй хамтран гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулна.	Аймгийн Цагдаагийн газраас “Архины зөвшөөрөл-шалгалт” “Хууль бус архи, спирт-илрүүлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулаад байна. Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийг оролцуулсан нийтийн эргүүлийн арга хэмжээг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөөд байна
		Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-уудад сургалт мэдээллийн ажил зохион байгуулна.	Одоогоор сургалт мэдээллийн ажил зохион байгуулаагүй байна.
		Харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд хууль тогтоомжийн мэдээллийн ажил зохион байгуулна	Аймгийн хэмжээнд “Камер хяналт”, “Харуул манаа хамгаалалт”, “Иргэдийн өмчийн хулгай-илрүүлэлт”, “Олон нийтийн эргүүл”, “Оюутан эргүүл”, “Хальтаргаа гулгаа”, “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсооё”, “Шатахуун түгээх станц-Хяналт”, “Эргүүл-Хяналт” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж нийт 252 байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчдад сургалт мэдээлэл зохион байгуулаад байна. Дээрх нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр телекамертай болох мэдэгдлийг 28 банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх газруудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон бусад	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн сургалтыг	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн сургалтыг тусгайлан хичээлээр оруулаа ажил зохион байгуулагдаагүй байна. Энэ ажлын хүрээнд иргэний боловсролын хичээлийн программд гэмт хэрэг түүний хор уршиг түүнээс урьдчилан	

1.3	хууль тогтоомжийн талаарх мэдээллийг их дээд сургуулийн оюутнууд болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад үе шаттайгаар хүргэх ажлыг зохион байгуулах /УТ-ий 1.3/	тусгайлан хичээлээр оруулан гэмт хэрэг түүний хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг өгнө.	сэргийлэх дадал хэвшлийг олгох хичээлийг оруулж ажиллаж байна.
		Гэмт хэрэг түүний хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх дадал хэвшил олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулан насанд хүрээгүй хүүхдийн хүүхэд гэмт хэрэг зөрчилд өртөж буй байдлыг бууруулна.	Гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа, түүнээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт багц 12 сургалтуудыг ерөнхий боловсролын 1001 сурагчдад зохион байгуулаад байна.
		Их, дээд сургуулийн оюутнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон бусад хууль тогтоомжийн талаарх эрх зүйн боловсрол олгох сургалтыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна	Нэгдсэн төлөвлөгөө батлуулаагүй боловч гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийн ажлыг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежид сар бүр Дорнод их сургуулийн оюутнуудад улирал бүр аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулж хэвшээд байна. 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 1700 гаруй оюутнууд сургалт мэдээллийн ажилд хамрагдаад байна.
1.4	Монгол улсын Хууль зүй дотоод хэргийн яамнаас 2017 оныг “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан иргэд олон нийтэд хууль тогтоомжийн сургалтыг үе шаттай зохион байгуулан нутгийн	Сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран сумдад ажиллах эрх зүйн хөтөч ухуулагчийг бэлтгэх сургалтыг зохион байгуулан иргэдийг сурган гэрчилгээжүүлэн гэрээ байгуулна	Эрх зүйн хөтөч бэлтгэх зорилгоор сумдад ажиллах иргэдийн судалгааг авсан. Энэхүү ажлыг дараа жил зохион байгуулахаар хойшлуулаад байна.
		Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд өдөр тутмын хэрэглээний хуулиар гарын авлага бэлтгэн хэвлүүлж тухай бүр өөрчлөлт хөдөлгөөнийг хийн албан хэрэгцээнд ашиглана.	Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд өдөр тутмын хэрэглээний хуулиар гарын авлага бэлтгэн хэвлүүлж тухай бүр өөрчлөлт хөдөлгөөнийг хийн албан хэрэгцээнд ашиглана.
		Хэрлэн сумын 10 багийн ажлын албыг хууль тогтоомжийн самбартай болгох ажлыг тусгуулж ЗДТГ-тай хамтран	Хэрлэн сумын 10 багийн ажлын албыг хууль тогтоомжийн самбартай болгох чиглэл өгсөн. Дээрх чиглэлийн хүрээнд Хэрлэн сумын 10 багийн ажлын алба ИТХ-ын ажлын албаар

	захиргааны байгууллагад хууль зүйн туслалцаа үзүүлэх	зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой байдлаар хууль тогтоомжийг түгээн ажиллана	дамжуулан шинээр батлагдсан болон шинэчлэн гарсан хууль тогтоомжийн гарын авлага материалыг тогтмол авч хэвшээд байна.
2 Архидан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд			
2.1	Иргэд, олон нийтэд архи согтууруулах ундааны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Аймгийн Цагдаагийн газрын саатуулах байранд саатуулагдсан иргэдэд сургалт сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна	Аймгийн Цагдаагийн газрын саатуулах байранд саатуулагдсан иргэдэд аймгийн Цагдаагийн газраас хууль тогтоомжийн өглөө болгон зохион байгуулж сэтгэл зүйн сургалт мэдээллийг төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагын сэтгэл зүйч нартай хамтран тогтмол зохион байгуулж хэвшээд байна. 2017 оны 09 дүгээр сарын байдлаар 143 удаагийн сургалтыг 3241 иргэнд зохион байгуулаад байна. Согтуугаар зөрчил гаргаж саатуулагдсан иргэдийн тоо 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 2618 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 349 буюу 11.7 хувиар буурсан байна.
		Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн албан хаагчийн манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад үе шаттай сургалт зохион байгуулна	Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн албан хаагчийн манлайллыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны А/191 дүгээр захирамжаар “Эрүүл нийгэм-Таны оролцоо аян”-г зарлан “Архигүй хамт олон, Архигүй сум шалгаруулах” болзолт уралдааныг зарлаад байна. Мөн аймгийн Засаг даргын 2017 оны А/303 дугаар захирамж, 04 дүгээр албан даалгавраар төрийн байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг өгч төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд архидан согтуурч зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг тодорхой тусгай чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
		Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ивээл дор архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд залуучуудад зөв, дадал, хэвшил олгох зорилгоор 14 сумын залуучуудын дунд “Спорт уу”-“Спирт үү” сэдэвт	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ивээл дор архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд залуучуудад зөв, дадал, хэвшил олгох зорилгоор 14 сумын залуучуудын дунд “Спорт уу”-“Спирт үү” сэдэвт хэмжээг эхлүүлсэн.

		волейболын лигийн тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулна .	
		Архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Архигүй хамт олон” шалгаруулна	Аймгийн Засаг даргын 2017 оны А/191 дүгээр захирамжаар “Архигүй хамт олон, Архигүй сум” шалгаруулах болзолт уралдааныг зарлан удирдамжийг хүргүүлсэн. Уралдааны материалыг 12 дугаар сарын 1-нийг хүртэл хүлээн авч 12 дугаар сарын 10-нд шалгаруулна.
2.2	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлын 2015 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх /АЭЗН-ийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 1.4.6/	“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж эрчимжүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулна	“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2017 оны 01 дүгээр улирлын байдлаар гарган дүн шинжилгээ хийж эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан “Эрүүл нийгэм-Таны оролцоо” архи согтууруулах ундаа хорт зуршлын эсрэг аяныг зохион байгуулсан.
		“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангана	“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж эрчимжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 22 ажлыг зохион байгуулахаар боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
		Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод журамд архидан согтууран төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээ зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгон тусгуулах ажлыг эрчимжүүлж зохион байгуулна	Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод журамд архидан согтууран төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээ зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгон тусгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын 2017 оны А/191, А/303, дугаар захирамж, 04 дүгээр албан даалгавраар агентлаг байгууллагын дарга нарт үүрэг чиглэл өгснөөс Засаг даргын дэргэдэх 20 агентлаг 17 төсөвт байгууллага дээрх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулаад байна.
2.3	“Архигүй амьдрал” хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан “Архигүй	“Архигүй амьдрал” зөвлөгөө өгөх кабинетийг үйл ажиллагааг эрчимжүүлэн архины хамаарал бүхий иргэдэд архинаас гаргах сайн дурын эмчилгээг үр дүнтэйгээр зохион байгуулан эмчилгээний дараах	“Архигүй амьдрал” зөвлөгөө кабинетийн үйл ажиллагаа одоогоор зогсоод байна. Архинаас гаргах сайн дурын эмчилгээг Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын санхүүжилтээр “Ухаарал” сэтгэц наркологийн эмнэлэг хийж байна. 2017 оны 09 дүгээр сарын байдлаар 90 иргэн архинаас гаргах сайн дурын эмчилгээнд

<p>амьдрал” зөвлөгөө өгөх кабинетийг БОЭТ-рүү шилжүүлэн үйл ажиллагааг эрчимжүүлэн иргэдийг архинаас гаргах сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах</p>	<p>хяналтыг гэр бүл, сум, баг эрүүл мэндийн байгууллагын хэмжээнд эрчимжүүлэн сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулна</p>	<p>хамрагдан мэргэжлийн эмчийн хяналтад байна. Архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор архи согтууруулах ундаа, хорт зуршлын эсрэг “Эрүүл нийгэм-Таны оролцоо” 1 сарын аяныг аймгийн Засаг даргын 2017 оны А/191 дүгээр захирамжаар зохион байгуулсан. Тус аяны хүрээнд архи согтууруулах ундаа, хорт зуршлын эсрэг нийгэмд эерэг давалгаа үүсгэх 30 ажил, арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн аймгийн Засаг даргын орлогчоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>“Эрүүл нийгэм-Таны оролцоо” аяны нээлтийн арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Нээлтийн ажиллагааны хүрээнд өсвөр үе, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж, өөрийгөө эрүүлээр хөгжүүлэх сэдлийг олон нийтэд төрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 35 секц, дугуйлан, клуб, сургалтын төвүүдийг сурталчлан танилцуулж, иргэд, олон нийтэд архи согтууруулах ундаа, хорт зуршлын эсрэг үйл ажиллагаанд нэгдэхийг уриалсан унадаг дугуйтай хөдөлгөөнийг өрнүүлсэн.</p> <p>“Эрүүл нийгэм-Таны оролцоо” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажил арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>-“Архи, согтууруулах ундаа, хорт зуршлын эсрэг залуучуудын үүрэг оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг салбар бүрийн төлөөлөл болсон 50 гаруй залуусыг оролцуулан зохион байгуулж уриалга гаргасан.</p> <p>-Архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, албан хаагчдын манлайллыг нэмэгдүүлэн нийгэмд эерэг давалгааг үүсгэх зорилгоор хөлбөмбөгийн тэмцээнийг 20 байгууллагын дунд зохион байгуулсан.</p> <p>-Хан-Уул цогцолбор сургуулиас “Эрүүл ирээдүйн төлөөх</p>
---	--	--

		<p>бидний оролцоо” ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулан 5 сургуулийн 200 орчим сурагчид хамрагдсан.</p> <p>-“Эрүүл нийгмийн төлөөх залуучуудын үүрэг оролцоо” уулзалт ярилцлагыг Дорнод аймгийн Залуучуудын нэгдэлтэй хамтран зохион байгуулж салбар бүрийн төлөөлөл болсон 50 гаруй залуусыг хамруулан тэдний санал бодлыг сонсож, хэлэлцүүлэг өрнүүллээ.</p> <p>-Архины хамаарал бүхий 83 иргэдийг баримт бичигжүүлэх, үзлэг оношилгоонд хамруулах ажлыг мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.</p> <p>-Аймгийн Цагдаагийн газраас “Архины зөвшөөрөл-шалгалт” “Хууль бус архи, спирт-илрүүлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулаад байна.</p> <p>-“Эрүүл нийгэм-Таны оролцоо” аяны хүрээнд архи, согтууруулах ундааны хэрэглээний сөрөг үр дагаврыг иргэдэд ухуулан нөлөөлөх, эдгээр хорт зуршил нь хувь хүн, хүүхэд гэр бүл, нийгэмд ямар сөрөг нөлөө үзүүлж байгааг ойлгуулах зорилготой “Өөрчлөлтийг яг одоо” сэдэвт захидлын уралдааныг зарлан иргэд, олон нийтээс 90 орчим захидлыг хүлээн аваад байна.</p> <p>Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран архинаас татгалзан 10 гаруй жил болсон 3 иргэнийг оролцуулсан хөрөг нэвтрүүлгийг бэлтгээд байна.</p> <p>Архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчдын манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор архи согтууруулах ундааны түүний хор хөнөөлийн талаарх сургалт мэдээллийн ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газар, “Ухаарал” ТББ, БОЭТ-тэй хамтран Зэвсэгт хүчний 327 дугаар анги, Хилийн 0132 дугаар анги, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ, Адуунчулуу ХХК, “ДБЭХС” ТӨХК, Дорнод гурил зэрэг 12 байгууллагын 355 ажилтан албан</p>
--	--	---

			хаагчдад зохион байгуулаад байна.
		Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран архианаас гарч ажил хөдөлмөр эрхлэн яваа иргэдийн талаар хөрөг нэвтрүүлэг хийлгэнэ.	Архинаас гарч 7-10 хугацаанд архи согтууруулах ундаа хэрэглээгүй хөдөлмөр эрхэлж байгаа н.Батхуяг н.Ганхуяг нар болон 3-5 жилийн архины хэрэглээгүй байгаа н.Мөнхбат нарын тухай хөрөг нэвтрүүлгийг орон нутгийн МИЖИ телевизтой хамтран хийгээд байна. /Нэвтрүүлгийн төгсгөлд н.Мөнхбатыг ажилтай болгох зорилгоор ХХҮГ-ын саналыг хүлээгээд олон нийтэд нэвтрүүлгээ цацаагүй байна./
<u>3. Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:</u>			
3.1	Бүх төрлийн <i>āyīò</i> <i>ōyōyāōyē</i> <i>òyìōyō</i> , урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулна	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг боловсруулаад байна. 2017 оны 4 дүгээр улиралд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. Замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичгийн төслийг аймгийн Цагдаагийн газартай хамтран боловсруулсан. Урьдчилсан хэлэлцүүлгийг бодлогын баримт бичгийн үйлчлэлд хамаарах зорилтот бүлгийн гишүүдэд зохион байгуулан холбогдох материалыг ирүүлэхийг аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт 2017 оны 06 дугаар сарын 20-нд чиглэл өгөөд байна.
		Аймгийн эрүү хэв журмын 2016 оны нөхцөл байдлын мэдээнд дүн шинжилгээ хийн аймгийн Засаг даргын албан даалгавар гарган өссөн үзүүлэлттэй байгаа тодорхой гэмт хэргийг бууруулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулна	Аймгийн эрүү хэв журмын 2016 оны нөхцөл байдлын мэдээнд дүн шинжилгээ хийж аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр албан даалгавар, 2017 оны хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийж тодорхой төрлийн гэмт хэрэг өсөлттэй байгаа баг, сумын гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэл өгсөн 2017 оны А/303 дугаар захирамжийг тус тус гарган хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.
		Байгалийн баялгийн зүй бус ашиглалтыг хянах, хяналт шалгалтын орчин үеийн тоног төхөөрөмж, камерыг Хэрлэн гол дээрх Баянтүмэнгийн гүүр болон ялалтын гүүрэнд суурилуулна	Байгалийн баялгийн зүй бус ашиглалтыг хянах, хяналт шалгалтын орчин үеийн тоног төхөөрөмж, камерыг Хэрлэн гол дээрх Баянтүмэнгийн гүүр болон ялалтын гүүрэнд суурилуулах ажлын тендер зарлагдан “Дорны арвижих” ХХК шалгаран БОАЖГ-тай гэрээ байгуулаад гүйцэтгэлийн шатанд байна.

	Улсын хилээр нэвтэрч буй гадаад дотоодын иргэдэд хилийн нэвтрэх хуудсанд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт өртөхгүй байх санамж сануулга өгөх ажлыг зохион байгуулна.	Улсын хилээр нэвтэрч буй гадаад дотоодын иргэдэд хилийн нэвтрэх хуудсанд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд өртөхгүй байх санамж, гарын авлагыг Хилийн 0132 дугаар ангийн хариуцсан хэсэг “Хавирга”-ын боомтод 10.000 гаруй хилээр нэвтэрч буй зорчигч нарт өгч, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулаад байна.
	Хорих ял эдлээд суллагдсан иргэдийн судалгааг сүүлийн 2 жилийн байдлаар гарган нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулна.	Аймгийн хэмжээнд сүүийн 2 жилийн байдлаар хорих ял эдлээд суллагдсан 48 иргэн байна. Тэдгээр иргэдийг дахин гэмт хэрэг зөрчил үйлдэхгүй байх чиглэлээр 3 удаагийн сургалтад 23 иргэнийг хамруулан итгэл найдварын хуудас гардуулан өгөөд байна.
	Аймгийн хэмжээнд сүм хийдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага иргэний судалгааг гарган хяналт тавьж ажиллана	Аймгийн хэмжээнд сүм хийдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага иргэний судалгааг гаргах ажил хийгдээгүй байна.
	Бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэм тогтоох болон бусад шаардлагаар пост ажиллуулахад зориулж зөөврийн пост худалдан авна.	Бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэм тогтоох болон бусад шаардлагаар пост ажиллуулахад зориулж зөөврийн постыг захиалан аймгийн Цагдаагийн газар 2017 оны 09 дүгээр сарын 8-ны өдөр хүлээн аваад байна.
	Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана.	Аймгийн Засаг даргын 2017 оны А/22 дугаар захирамжаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлээд байна.
	Аймгийн хэмжээнд бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр олон нийтийн эргүүл зохион байгуулна. /ГХУС тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль г.м/	Аймгийн хэмжээнд бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр олон нийтийн эргүүл аймгийн Засаг даргын захирамжаар 3 дугаар улиралд зохион байгуулна.
	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гудамж талбайн хяналтын	Аймгийн Засаг даргын 2017 оны А/92 дугаар захирамжаар гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гудамж талбайн хяналтын

		камерын сүлжээ ашиглалтын зардалд дэмжлэг үзүүлэн ажиллана	камерын сүлжээ ашиглалтын зардалд дэмжлэг үзүүлээд байна.
3.2	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	Малчдын бүлэг холбоодыг байгуулж сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Малчдын бүлэг холбоодын судалгааг 14 сумаас авч аймгийн Цагдаагийн 2017 оны 06 дугаар сард хүргүүлээд байна.
		Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулж мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулна	Аймгийн Цагдаагийн газраас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулснаар мал хулгайлах гэмт хэрэг 27 үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 хэрэг буй 34.1 хувиар буурсан байна.
3.3	Нóíäüí ГХУСАЗСЗ-ийн ажилтай танилцан мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгөх	Нóíäüí äýìò õýðäýýñ óðüä-èèäí ñýðäèèèýò àæèüã çìèèòòòèäò ñàèääð ç°äè°èèéí àæилтай танилцан зөвлөмж өгч, сум багт, эрх зүйн сургалт сурталчилгаа, хууль зүйн туслалцааны чиглэлээр нэгдсэн арга хэмжээ зохион байгуулна	Сóíäüí äýìò õýðäýýñ óðüä-èèäí ñýðäèèèýò àæèüã çìèèòòòèäò ñàèääð ç°äè°èèéí àæилтай танилцан зөвлөмж өгч, сум багт, эрх зүйн сургалт сурталчилгаа, хууль зүйн туслалцааны чиглэлээр нэгдсэн арга хэмжээг 2017 оны 9,10 дугаар саруудад зохион байгуулахаар төлөвлөөд байна.
		Сумын ГХУСАЗСЗ-ийн гишүүд болон сум багийн Засаг дарга нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага бэлтгэн хүргүүлнэ	Сумын ГХУСАЗСЗ-ийн гишүүд болон сум багийн Засаг дарга нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага бэлтгэн хүргүүлэх ажил хийгдээгүй байна.
<u>4. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:</u>			
4.1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх	Чойбалсан хотын авто замын уулзваруудад гэрлэн дохио суурилуулна	Орон нутгийн хөгжлийн сангийн 30.000.000 төгрөгийн санхүүжилтээр тэмдэг тэмдэглэгээ хийх ажлын тендер зарлагдаж “Түмэн цогт бадрах” ХХК шалгаран гүйцэтгэгчээр ажиллаж Дорнод их сургууль, 9 дүгээр цэцэрлэгийн орчимд хамгаалалтын хайс, явган зорчигчийн гарц, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ болон бусад шаардлагатай зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг

<p>ажлыг үе шаттай зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг хангах</p>		хйиж гүйцэтгэн хүлээлгэж өгөөд байна.
	Улсын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаж буй “Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр”-т зориулан сургалт мэдээллийн болон нөлөөллийн ажил зохион байгуулна	“Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр” 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулагдана.
	“Сургуулийн бүс”, “Цэцэрлэгийн бүс”-2 төсөл хэрэгжүүлнэ	Сургууль цэцэрлэгийн бүс төслийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 30.000.000 төгрөгийн санхүүжилтээр тэмдэг тэмдэглэгээ хийх ажлын тендер зарлагдаж “Түмэн цогт бадрах” ХХК шалгаран гүйцэтгэгчээр ажиллаж Дорнод их сургууль, 9 дүгээр цэцэрлэгийн орчимд хамгаалалтын хайс, явган зорчигчийн гарц, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ болон бусад шаардлагатай зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг хйиж гүйцэтгэн хүлээлгэж өгөөд байна.
	Замын хөдөлгөөний дүрмийн талаарх мэдлэг олгох “Ногоон гэрэл-цагаан шугам” цэцэрлэгийн насны хүүхдийн дунд, “Замын хөдөлгөөний цагаан толгой-2017” тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулна	Замын хөдөлгөөний дүрмийн талаарх цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд, “Замын хөдөлгөөний цагаан толгой-2017” тэмцээнийг 2017 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнийг 2017 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөөд байна.
	Замын тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цацруулагчтай цүнхний уут” арга хэмжээг зохион байгуулна	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг замын тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цацруулагчтай цүнхний уут”-ыг ЕБС-ийн 2-3 дугаар ангийн сурагчдад 2017 оны 10 дугаар сарын 1-ний өдөр соёл хүмүүжлийн ажлын нээлтээр тараахаар төлөвлөөд байна. Тус цүнхний уутыг оёулах ажлыг Замын цагдаагийн тасаг хариуцан гүйцэтгэж байна.
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд	Аймгийн Засаг даргын захирамжаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа бэлэн бус торгуулийн	

		ашиглагдаж байгаа бэлэн бус торгуулийн машины сүлжээ ашиглалтын зардлыг шийдвэрлэнэ	машины сүлжээ ашиглалтын зардалд дэмжлэг үзүүлээд байна.
<u>5. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:</u>			
5.1	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгууларх	Байгаль орчны эсрэг болон хулгайн ан, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөнт пост ажиллуулна.	Байгаль орчны эсрэг болон хулгайн ан, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөнт постуудыг тухай бүр гарган ажиллуулаад байна.
		Эрчим хүчний шугам болон шонгийн модны аюулгүй байдлыг ханган ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Эрчим хүчний шугам болон шонгийн модны аюулгүй байдлыг ханган ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулаагүй байна.
5.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Ульхан боомтоос баруун тийш Хэрийн гол хүртэл ОХУ-тай хиллэдэг хэсгээр түймрээс хамгаалах шороон зурвас 25 км-ыг татан хуучин зурвасыг сэргээнэ.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ульхан боомтоос баруун тийш Хэрийн гол хүртэл ОХУ-тай хиллэдэг хэсгээр түймрээс хамгаалах шороон зурвас 25 км-т шороон зурвас татах ажлын гүйцэтгэлийг Хилийн 0275 дугаар анги хариуцан гүйцэтгэхээр гэрээ байгуулаад байна.
		Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шороон зурвас Булган суманд татна.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шороон зурвас татах ажлын эрх Булган сумын Засаг даргад шилжсэн бөгөөд тус сумаас тендер шалгаруулалтын ажлыг зарлаад байна.
<u>6. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүүхдийн эрхийг хангах ажлын хүрээнд:</u>			
6.1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх урьдчилан	Гэр бүлийн хүчирхийлэл хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зохион байгуулна.	Гэр бүлийн хүчирхийлэл хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2017 оны 4 дүгээр сард “ЛЕОС” төрийн бус байгууллага зохион байгуулсан.

<p>сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг хангана</p>	<p>Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг зөрчлийн судалгааг гарган дүн шинжилгээ хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно</p>	<p>Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг зөрчил 2017 оны хагас жилийн байдлаар гэмт хэрэг 6, зөрчил 107 бүртгэгдсэн байна. Судалгаанд дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй байна.</p>
	<p>Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах эрх зөрчигдсэн хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах байрны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах эрх зөрчигдсэн хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах байрны үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын захирамжаар 8.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>
	<p>Аймгийн Цагдаагийн газрын албан хаагчид болон хүүхэд хамгааллын ажилтан, сум багийн нийгмийн ажилтнуудыг хамруулсан “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулан зөвлөмж гарган хэрэгжилтийг хангуулж ажиллана.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, хууль сахиулах болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамтарсан багийг ажиллуулж байна. Мөн зорилтот бүлгийн 50 гэр бүлд “Гэр бүл хөгжил дэвшил” 3 хөтөлбөрийг хэрэгжүүлэн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Мөн Дэлхийн гэр бүлийн өдрийг угтаж Боловсрол соёл урлагийн газар, Цагдаагийн газар, Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ” зөвлөгөөнийг 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль багийн нийгмийн ажилтнууд болон хамтарсан багийн гишүүдийг оролцуулсан</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтныг сургах мэргэшүүлэх, арга зүйн удирдлагаар хангах ажлын хүрээнд сум,хороо /баг/-ийн түвшинд ажиллаж буй хамтарсан багийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж чадавхжуулах нэгдсэн арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Хөгжимт драмын театрт зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ чуулган”, “Эрсдэлтэй гэр бүлтэй ажиллах хамтарсан багийн зөвлөгөөн”, “Хүүхэд, гэр бүлд хүргэх сэтгэл зүйн үйлчилгээ”, “Гэрлэлт ба үүрэг хариуцлага”, “Хүүхдийн эрх</p>

			хамгаалал, хууль эрх зүйн шинэчлэл”, салбар зөвлөгөөн, сургалтууд зохион байгуулагдсан. Давхардсан тоогоор нийт 7575 иргэд олон нийт албан тушаалтнууд хамрагдаж гэр бүлтэй ажиллах үүрэг хүлээгчдийн хариуцлага болон иргэдийн хууль эрх зүй, гэр бүлийн үүрэг, хариуцлагыг тодорхой түвшинд нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.
6.2	Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах /АЭЗН-ийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 1.4.5/	“Хүүхдийн хууль зүйн хороо”-ны үйл ажиллагааг эрчимжүүлэн насанд хүрээгүй хүүхэд гэмт хэргийн хохирогч холбогдогч, сэжигтэн болж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргана. Гэмт хэрэгт холбогдож буй хүүхдүүдийн нэгдсэн мэдээллийн дата баазтай болж сургалт мэдээллийн ажлыг эрчимжүүлнэ	Энэ чиглэлийн ажлыг зохион байгуулаагүй байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх насанд хүрээгүй хүүхэд гэмт хэрэгт холбогдож буй байдалд дүгнэлт хийж, хууль хяналтын байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа хяналтыг сайжруулан мэдээллийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх зорилгоор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэдээллийн сангийн Хамгаалал шаардлагатай хүүхдийн эрсдэлийн түвшин тогтоох программ хангамжид суурилан Гэмт хэрэгт холбогдсон болон гэрч, хохирогч, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүүхдийн талаар шинэ өгөгдөл нэвтрүүлэх ажлыг “ БААМБАЛБИ ХХК” хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөөд байна.
<u>7. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:</u>			
7.1	Аймгийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн ГХУСАЗС-ийн дэргэдэх “Олон нийтийн дэд зөвлөл”-тэй хамтран Авлигын эсрэг хууль, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд танилцуулах нэгдсэн зөвлөгөөнийг	Аймгийн ГХУСАЗС-ийн дэргэдэх “Олон нийтийн дэд зөвлөл”-тэй хамтран Авлигын эсрэг хууль, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд танилцуулах нэгдсэн зөвлөгөөнийг 2017 оны 12 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж байна. /Дэлхийн авлигын эсрэг өдөр/

		зохион байгуулан авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлнэ	
		Аймгийн хэмжээнд хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллана	Аймгийн хэмжээнд хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 223 албан тушаалтан ХАСХОМ-оо хуулийн хугацаанд нь мэдүүлээд байна.
<u>8.Хяналт шалгалтын чиглэлээр</u>			
8.1	Хуулийн тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газруудад “Хүүхэд хамгаалал-хяналт” арга хэмжээг зохион байгуулна	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 12 цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд аймгийн Цагдаагийн газар Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрууд хамтран хяналт шалгалтын ажлыг 2017 оны 0, 7 дугаар саруудад зохион байгууллаа. Тус хяналт шалгалтын явцад холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 2 газрын үйл ажиллагааг зогсоож хаах арга хэмжээ авч ажилласан.
		Аймгийн хэмжээнд оюутан сурагчдыг гэмт хэрэг зөрчилд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Багш-эргүүл” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна	Аймгийн хэмжээнд оюутан сурагчдыг гэмт хэрэг зөрчилд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Багш-эргүүл” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 3 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөөд байна.
		Тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодис ашигладаг аж ахуй нэгж байгууллагуудад аймгийн ГХУСАЗС-ийн гишүүд хамтран үзлэг шалгалт зохион байгуулна	Энэ чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулаагүй байна.

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН М.НЯМСҮРЭН
ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ц.БАЯРЖАРГАЛ